



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 15 өдөр

№ 01

Дархан уул аймаг

**Компанийн засаглалын баримт бичгүүд батлах тухай**

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Тээвэр Дархан” ХК-ийн дор дурдсан засаглалын журам, баримт бичгүүдийг баталсугай. Үүнд:
  - 1.1. “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг 1 дүгээр Хавсралтаар;
  - 1.2. “Хувьцаа эзэмшигчдийн хурын зар хүргэх журам” -ыг 2 дугаар Хавсралтаар;
  - 1.3. “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ыг 3 дугаар Хавсралтаар;
  - 1.4. “Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ыг 4 дүгээр Хавсралтаар;
  - 1.5. ТУЗ-ийн “Аудитын хорооны журам”-ыг 5 дугаар Хавсралтаар,
  - 1.6. ТУЗ-ийн “Нэр дэвшүүлэх хорооны журам”-ыг 6 дугаар Хавсралтаар,
  - 1.7. ТУЗ-ийн “Цалин, урамшуулалын хорооны журам”-ыг 7 дугаар Хавсралтаар,
2. Хууль тогтоомж, холбогдох журмыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.САРУУЛ



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 25 өдөр

№ 02

Дархан уул аймаг

**ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах тухай**

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, “Тээвэр Дархан” Хувьцаат компанийн дүрмийн 13.1 дэхь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ТУЗ-ийн дэргэд Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Аудитын хороо байгуулсугай.
2. ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:
  - А. Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо:  
ТУЗ-ийн гишүүн: М.Жавхлан, Л.Амарсанаа  
ТУЗ-ийн хараат бус гишүүн: Д.Чулуун,
  - Б. Аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр:
3. ТУЗ-ийн гишүүн: М.Очирсүх  
ТУЗ-ийн хараат бус гишүүн: Д.Бумцэрэн, Х.Жаргалсайхан
4. Нэр дэвшүүлэх, цалин урамшуулалын хорооны даргаар Л.Амарсанаа, Аудитын хорооны даргаар Д.Бумцэрэн нарыг тус тус томилсугай.
5. Хууль тогтоомж, холбогдох журмыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал (М.Оюун)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.САРУУЛ



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 14 өдөр

№ 01

Дархан уул аймаг

**Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох,  
нарийн бичгийн даргыг томилох тухай**

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 78.1 дахь заалт, 82.1 дэхь заалт, “Тээвэр дархан” ХК-ийн дүрмийн 10.1 дэхь заалт, 12.1 дэхь заалт, 2022 оны 5 сарын 14-ны өдрийн хуралдаан тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Батмөнх овогтой Саруулыг сонгосугай.
2. Тус компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Эрдэнэхүү овогтой Жавхлантөгсийг томилсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.САРУУЛ